



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

**Дуудлага худалдааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38-44 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг хувьчлах журам”, “Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 3.2.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/264 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны ...03... дугаар сарын
03...-ний өдрийн 01/03... тушаалын хавсралт

Дуудлага худалдааг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Рэнцэнбямба

Орлогч дарга

Гишүүд:

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
дарга

Н.Уранчимэг

Ерөнхий нягтлан бодогч

Дуудлагын худалдааны хөтлөгч:

Б.Мөнхбаатар

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн
мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч:

Ч.Мөнхбаяр

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн өмч
хувьчлал хариуцсан ахлах мэргэжилтэн

М.Энхбаяр

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн өмч
хувьчлал хариуцсан мэргэжилтэн